



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/93/НА- СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор хот</p> <p>2023 оны 02 дугаар сарын 20-ний өдөр</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: <a href="mailto:doljmaab@audit.gov.mn">doljmaab@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр: “Номгон Аудит” ХХК Захирал: Г.Саранчимэг Аудитор: О.Мандах Утас: 89010203 Цахим хаяг: <a href="mailto:audit.nomgon@gmail.com">audit.nomgon@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
Аудитын гол асуудал .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ЛАБОРТОРИ НОМУНДАЛАЙ  
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

2024.02.23 № 2/29

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд 6,586,705.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 6,548,520.2 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст харилцах дансанд 275,252.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/325 тоот тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн чанар, үр дүнгээр 3-р

5020135

түвшинд үнэлэгдэн 95,591.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгогдсон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.5 хувиар үнэлсэн байна. Баянхонгор сумын лаборатори Номундалай цогцолбор сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>301,095,364.99</b>	<b>620,526,527.68</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>38,185,578.02</b>	<b>275,252,498.91</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>38,185,578.02</b>	<b>275,252,498.91</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>38,185,578.02</b>	<b>275,252,498.91</b>
31211	Төрийн сангийн харилцах	38,185,578.02	275,252,498.91
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,509,373.76</b>	<b>1,108,248.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	148,288.56	2,748.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,000,000.00	1,000,000.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>361,085.20</b>	<b>105,500.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	361,085.20	105,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>261,400,413.21</b>	<b>344,165,780.77</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>5,525,700.00</b>	<b>2,688,700.00</b>
35130	Эм боох материал	5,525,700.00	2,688,700.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>255,874,713.21</b>	<b>341,477,080.77</b>
35410	Бичиг хэргийн материал	5,588,000.00	14,172,300.00
35420	Аж ахуйн материал	9,461,312.00	4,841,400.00
35450	Барилгын засварын материал	5,954,540.21	4,634,540.21
35460	Хүнсний материал	0	595,163.80
35470	Бусад хангамжийн материал	234,870,861.00	317,233,676.76
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,566,749,717.34</b>	<b>10,378,158,079.68</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>10,566,749,717.34</b>	<b>10,378,158,079.68</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>9,677,634,050.52</b>	<b>9,491,930,412.78</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,695,591,267.00	9,658,980,767.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-575,116,249.13	-756,579,889.13
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	821,127,392.31	800,327,766.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-467,109,973.52	-411,283,099.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	376,958,446.32	400,170,106.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-212,977,440.66	-238,845,846.23
39217	Ном	39,160,608.20	39,160,608.20
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>889,115,666.82</b>	<b>886,227,666.90</b>
39301	Программ хангамж	13,715,000.00	13,715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,894,333.18	-8,782,333.10
39303	Бусад биет бус хөрөнгө	881,295,000.00	881,295,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>10,867,845,082.33</b>	<b>10,998,684,607.36</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,640,652.67</b>	<b>365,750.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,640,652.67</b>	<b>365,750.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>2,640,652.67</b>	<b>365,750.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,214,762.87	365,750.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,425,889.80</b>	<b>0</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,425,889.80	0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,865,204,429.66</b>	<b>10,998,318,857.36</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>10,865,204,429.66</b>	<b>10,998,318,857.36</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,483,997,027.68	2,483,997,027.68
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,483,997,027.68	2,483,997,027.68
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>7,191,123,690.42</b>	<b>7,360,848,618.12</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-3,666,740,370.03	7,227,734,190.42
51220	Тайлант үеийн үр дүн	10,857,864,060.45	133,114,427.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,190,083,711.56	1,153,473,211.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>10,867,845,082.33</b>	<b>10,998,684,607.36</b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /ТӨГРӨГӨӨР/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>16,652,302,352.87</b>	<b>6,608,935,665.76</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,322,531,152.87</b>	<b>208,335,465.76</b>
120	Нийтлэг татварын бус орлого	11,322,531,152.87	208,335,465.76
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>79,765,999.00</b>	<b>147,920,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,765,999.00	143,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	4,420,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,969,361,422.69	12,695,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	273,403,731.18	47,720,465.76
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,329,771,200.00</b>	<b>6,400,600,200.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,349,982,200.00</b>	<b>5,541,004,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,349,982,200.00	5,541,004,200.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>50,578,700.00</b>	<b>0</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,578,700.00	0
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>929,210,300.00</b>	<b>859,596,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	929,210,300.00	859,596,000.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,612,458,451.33</b>	<b>6,475,548,238.24</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,612,458,451.33</b>	<b>6,475,548,238.24</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,316,038,313.35</b>	<b>6,178,540,983.78</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,468,104,641.87</b>	<b>4,182,222,372.60</b>
210101	Үндсэн цалин	1,889,193,758.00	2,326,409,890.03
210102	Нэмэгдэл	1,383,575,066.87	1,697,029,632.76
210104	Урамшуулал	82,414,617.00	158,782,849.81
210105	Гэрээт ажлын хөлс	112,921,200.00	0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>432,878,126.12</b>	<b>518,357,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	294,706,152.78	352,122,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	36,796,100.34	41,558,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,931,173.69	33,246,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,366,041.31	8,311,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	67,078,658.00	83,118,000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>787,340,725.86</b>	<b>838,930,695.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	53,118,329.86	52,721,689.94
210302	Түлш, халаалт	640,974,112.00	697,217,618.00
210303	Цэвэр, бохир ус	93,248,284.00	88,991,388.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>52,907,446.04</b>	<b>97,164,874.00</b>
210401	Бичиг хэрэг	13,251,900.00	56,309,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,116,243.28	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,702,835.37	39,242.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,600.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,223,620.49	40,816,032.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	11,564,246.90	0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>85,011,013.00</b>	<b>58,095,850.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,787,628.00	0
210502	Хоол, хүнс	74,223,385.00	58,095,850.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,952,021.80</b>	<b>34,593,130.00</b>
210604	Урсгал засвар	18,952,021.80	34,593,130.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,025,000.00</b>	<b>21,175,214.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	2,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	10,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,025,000.00	19,164,714.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>446,819,338.66</b>	<b>428,000,947.24</b>

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАА ДҮГНЭЛТ

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,638,274.40	71,155,109.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,480,200.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	335,700,864.26	356,845,837.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>296,420,137.98</b>	<b>297,007,254.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>296,419,346.00</b>	<b>297,007,224.20</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	246,340,646.00	234,872,924.20
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,078,700.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	62,134,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>791.98</b>	<b>30.26</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	791.98	30.26
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>11,039,843,901.54</b>	<b>133,387,427.52</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>181,979,841.09</b>	<b>272,999.82</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	181,979,841.09	272,999.82
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>10,857,864,060.45</b>	<b>133,114,427.70</b>

### 2.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,409,537,199.00</b>	<b>6,548,520,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>79,765,999.00</b>	<b>147,920,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>79,765,999.00</b>	<b>147,920,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>79,765,999.00</b>	<b>147,920,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,982,999.00	143,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,783,000.00	4,420,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,329,771,200.00</b>	<b>6,400,600,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,349,982,200.00</b>	<b>5,541,004,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,349,982,200.00	5,541,004,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>50,578,700.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,578,700.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>929,210,300.00</b>	<b>859,596,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	929,210,300.00	859,596,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,256,282,620.98</b>	<b>6,155,621,079.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,256,282,620.98</b>	<b>6,155,621,079.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,960,276,326.02</b>	<b>5,865,455,892.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,467,901,328.32</b>	<b>4,182,925,844.91</b>
210101	Үндсэн цалин	1,994,118,850.52	2,326,409,890.33
210102	Нэмэгдэл	1,278,446,660.80	1,697,029,632.86
210104	Урамшуулал	82,414,617.00	159,486,321.72
210105	Гэрээт ажлын хөлс	112,921,200.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>432,310,369.11</b>	<b>518,357,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	296,419,999.40	352,122,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	34,395,700.00	41,558,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,516,300.00	33,246,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,878,800.00	8,311,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	67,099,569.71	83,118,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>789,173,108.02</b>	<b>836,595,999.74</b>
210301	Гэрэл, цахилгаан	54,950,712.02	52,554,884.74
210302	Түлш, халаалт	640,974,112.00	695,138,507.00

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	93,248,284.00	88,902,608.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>73,275,200.00</b>	<b>66,893,287.00</b>
210502	Хоол, хүнс	73,275,200.00	66,893,287.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,000,000.00</b>	<b>22,999,970.00</b>
210604	Урсгал засвар	13,000,000.00	22,999,970.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33,815,466.70</b>	<b>23,583,038.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,283,000.00	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,532,466.70	21,583,038.80
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>150,800,853.87</b>	<b>214,099,852.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,709,553.87	145,139,652.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,091,300.00	68,960,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>296,006,294.96</b>	<b>290,165,186.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>296,005,502.98</b>	<b>290,165,156.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	245,926,802.98	228,030,856.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,078,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	62,134,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>791.98</b>	<b>30.26</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	791.98	30.26
213404	Хөрөнгийн	0.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>153,254,578.02</b>	<b>392,899,120.89</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>115,069,000.00</b>	<b>155,832,200.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>115,069,000.00</b>	<b>155,832,200.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>115,069,000.00</b>	<b>155,832,200.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	115,069,000.00	155,832,200.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-115,069,000.00</b>	<b>-155,832,200.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>38,185,578.02</b>	<b>237,066,920.89</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	38,185,578.02
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,185,578.02	275,252,498.91

#### 2.4 АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,600,184,711.56	7,000,826,639.52	11,085,008,378.76
C02	Нягтлан бодох	00.00	00.00	392,167,300.00	392,167,300.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГИЭЛТ

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.68</b>	<b>1,600,184,711.56</b>	<b>7,392,993,939.52</b>	<b>11,477,175,678.76</b>
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	382,745,375.57	382,745,375.57
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.68</b>	<b>1,190,083,711.56</b>	<b>7,191,123,690.42</b>	<b>10,865,204,429.66</b>
D01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.68</b>	<b>1,190,083,711.56</b>	<b>7,191,123,690.42</b>	<b>10,865,204,429.66</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	36,610,500.00	36,610,500.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.68</b>	<b>1,190,083,711.56</b>	<b>7,227,734,190.42</b>	<b>10,901,814,929.66</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-36,610,500.00	00.00	-36,610,500.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	133,114,427.70	133,114,427.70
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,483,997,027.68</b>	<b>1,153,473,211.56</b>	<b>7,360,848,618.12</b>	<b>10,998,318,857.36</b>

**2.5 АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗӨРҮҮ	Гүйцэтгэлийн хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,586,705,600.00</b>	<b>6,311,453,279.11</b>	<b>-275,252,320.89</b>	<b>95.82</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,586,705,600.00</b>	<b>6,311,453,279.11</b>	<b>-275,252,320.89</b>	<b>95.82</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,243,310,100.00</b>	<b>6,021,288,092.85</b>	<b>-222,022,007.15</b>	<b>96.44</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>4,329,866,500.00</b>	<b>4,182,925,844.91</b>	<b>-146,940,655.09</b>	<b>96.61</b>
210101	Үндсэн цалин	2,959,396,300.00	2,326,409,890.33	-632,986,409.67	78.61
210102	Нэмэгдэл	1,203,465,900.00	1,697,029,632.86	493,563,732.86	141.01
210104	Урамшуулал	167,004,300.00	159,486,321.72	-7,517,978.28	95.50
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>540,104,400.00</b>	<b>518,357,900.00</b>	<b>-21,746,500.00</b>	<b>95.97</b>
210201	Тэтгэврийн даатгал	366,909,500.00	352,122,400.00	-14,787,100.00	95.97
210202	Тэтгэмжийн даатгал	43,298,700.00	41,558,800.00	-1,739,900.00	95.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,639,000.00	33,246,800.00	-1,392,200.00	95.98
210204	Ажилгүйдлийн даатгал	8,659,800.00	8,311,900.00	-347,900.00	95.98

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	86,597,400.00	83,118,000.00	-3,479,400.00	95.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>836,596,000.00</b>	<b>836,595,999.74</b>	<b>-0.26</b>	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	57,500,000.00	52,554,884.74	-4,945,115.26	91.40
210302	Түлш, халаалт	686,596,000.00	695,138,507.00	8,542,507.00	101.24
210303	Цэвэр, бохир ус	92,500,000.00	88,902,608.00	-3,597,392.00	96.11
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>107,057,600.00</b>	<b>66,893,287.00</b>	<b>-40,164,313.00</b>	<b>62.48</b>
210502	Хоол, хүнс	107,057,600.00	66,893,287.00	-40,164,313.00	62.48
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00	0.00	0,0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,000,000.00</b>	<b>22,999,970.00</b>	<b>-30.00</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	23,000,000.00	22,999,970.00	-30.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33,863,700.00</b>	<b>23,583,038.80</b>	<b>-10,280,661.20</b>	<b>69.64</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,863,700.00	21,583,038.80	-10,280,661.20	67.74
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>372,821,900.00</b>	<b>369,932,052.40</b>	<b>-2,889,847.60</b>	<b>99.22</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,126,300.00	300,971,852.40	-1,154,447.60	99.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	70,695,600.00	68,960,200.00	-1,735,400.00	97.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>343,395,500.00</b>	<b>290,165,156.00</b>	<b>-53,230,344.00</b>	<b>84.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>343,395,500.00</b>	<b>290,165,156.00</b>	<b>-53,230,344.00</b>	<b>84.50</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	281,261,200.00	228,030,856.00	-53,230,344.00	81.07
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,134,300.00	62,134,300.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,548,520,200.00</b>	<b>6,548,520,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,541,004,200.00</b>	<b>5,541,004,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,541,004,200.00	5,541,004,200.00	0.00	100.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>186,105,400.00</b>	<b>147,920,000.00</b>	<b>-38,185,400.00</b>	<b>79.48</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	143,500,000.00	143,500,000.00	0.00	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,420,000.00	4,420,000.00	0.00	100.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,185,400.00	0.00	-38,185,400.00	0.00

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номундалай сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	38,185,578.02	38,185,578.02	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	275,252,498.91	275,252,498.91	
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>170.00</b>	<b>170.00</b>		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	124.00	124.00		
620003	Үйлчлэх ажилтан	45.00	45.00		
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>2,378.00</b>	<b>2,378.00</b>		
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>2,378.00</b>	<b>2,378.00</b>		
630001	Төрийн өмчит ЕБС	2,378.00	2,378.00		

### 3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 71 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, биелэлт 99.5 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу лаборатори Номундалай цогцолбор сургуулийн захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар сургуулийн зөвлөл, хүүхэд хөгжлийн алба, сургалтын алба, захиргаа аж ахуй гэсэн бүтэц зохион байгуулалттай 179 орон тоотой байхаар батлан 172 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ц.Алтангэрэл , 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ 2023 оны 01-р сарын 01 -нээс 03 дугаар сарын 30 хүртэл, нягтлан бодогч П.Амаржаргал 04-р сарын 01-нээс 12-р сарын 31 хүртэлх хугацаанд зурсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн

даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2 өдрийн 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”, 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 131 дүгээр тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12 өдрийн А/170 дугаар тушаал “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал” мөн 2022 оны 10 дугаар сарын 26 өдрийн А/430 “Багшийн ажлыг үнэлэх журам” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж ажиллаж байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшинд гүйцэтгэл үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл чанар үр дүнг улсын хэмжээнд нэгдсэн шалгуураар хөндлөнгөөс үнэлж гүйцэтгэлийн урамшуулал олгох, багийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, сургалт үйл ажиллагаанд хамруулах зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс өгсөн чиглэл дагуу бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130,839.5 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	38,185.60	275,252.50	237066.9
Авлага	1,506.60	1,105.50	-401.1
Бараа материал	261,400.40	344,165.70	82,765.30
Үндсэн хөрөнгө	10,566,749.70	10,378,158.10	-188,591.60
<b>Нийт хөрөнгө</b>	<b>10,867,845.10</b>	<b>10,998,684.60</b>	<b>130,839.50</b>
Өр төлбөр	2,640.60	365.7	-2,274.90
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>10,865,204.40</b>	10,998,318.80	133,114.40
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>10,867,845.10</b>	<b>10,998,684.60</b>	<b>130,839.50</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын Номундалай сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номундалай цогцолбор сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материалын данс байна.

Тайлант онд төрийн сангийн санхүүжилтийн дансаар санхүүжилтийн орлого 5,541,004.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 167,151.7 мянган төгрөг төвлөрч, зарлага санхүүжилтийн 5,478,832.3 мянган төгрөгийн гүйлгээг хийж 275,252.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Бараа материалын үлдэгдэл 85,602.3 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-наас ирүүлсэн 36,765.4 мянган төгрөгийн түрээсийн сурах бичиг, багш ажилчдын хандиваар 10,955.0 мянган төгрөгийн хөгжмийн зэмсэг тоглолтын хувцас зэрэг зүйлс голлох нөлөө үзүүлжээ.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 13/08 тогтоолыг үндэслэн 202,725.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан данснаас хассан бөгөөд БШУС-ын 2023 оны 5-р сарын 19 өдрийн А/230 тушаалаар батлагдсан нөхөн хангалт болон сургуулийн үнэлгээний урамшууллын зардлыг эх үүсвэр болгон цахим анги байгуулахад нэн шаардлагатай ширээ сандал тоног төхөөрөмж 155,832.2 мянган төгрөгөөр худалдан авч, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 12,695.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 133,114.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 10,998,684.6 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 36,610.5 мянган төгрөгөөр өөрчлөгдсөн нь дахин үнэлгээний үлдэх өртөгтэй хөрөнгө акталсантай холбоотой байна. Тайлант үеийн үр дүн 133,114.4 мянган төгрөгөөр нэмэгдэн 10,998,684.6 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,076,261.1 мянган төгрөгөөр төлөвлөж, 2022.07.25-ны өдөр аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд хэд хэдэн удаа өөрчлөлт орж БЕГ-ын даргын 2023 оны А/461 тоот тушаалаар улсын төсвөөс 5,727,109.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин, цалингийн шатлал нэмэгдсэнтэй холбоотой цалин хөлс түүнтэй адилтгах зардлыг 1,157,373.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 143,543.8 мянган төгрөгөөр тус тус дээд шатны байгууллагаас оны эхний төсвөөс нэмэгдүүлэн баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 5,541,004.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 5,265,751.9 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 275,252.3 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 859,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл гараагүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	12,749.8	12,744.85	4.95	99.96
2	80312 Сургалт семинар	6,476.4	6,476.4	0.0	100.0
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	22,611.4	22,600.0	11.4	99.95
4	81801 Үдийн цай хөтөлбөр	281,261.2	228,030.86	53,230.34	81.07
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	111,601.7	71,434.12	40,167.58	64.00
6	81816 Хүүхдэд эзлтэй сургалтын орчин	128,956.4	128,956.4	0.0	100.0
7	81823 Боловсролын байгууллагын багш	28,900.9	28,900.9	0.0	100.0
8	81827 Бичиг үсгийн боловсрол олгох хөтөлбөр	4,186.0	4,186.0	0.0	100.0
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	103,691.2	91,679.18	12,012.02	88.4
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	95,591.2	95,550.1	41.4	99.99
11	81848 Сурах бичгийн түрээс	2,000.0	2,000.0	-	100.0
12	81844 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	59,112.6	58,925.67	186.93	99.6
	ДҮН	857,138.8	751,484.47	105,654.23	87.67

Эх сурвалж: Баянхонгор сумын Номундалай сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Номундалай сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 281,261.2 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны 107,057.6 мянган төгрөгийн төсөв тус тус батлагдаж зардал бүрд 4 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгэлээр 228,030.8 мянган төгрөгийн үдийн цайны хүнсний материал, 66,893.2 мянган төгрөгийн дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материал худалдан авсан байна. Тендер шалгарсан гэрээ байгуулж ажилласан аж ахуй нэгжүүдийг багц тус бүрээр доорх хүснэгтээр харуулав.

№	Зардлын нэр	Багц			
		Мах махан бүтээгдэхүүн	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Гурил үр тариа бусад хүнсний бүтээгдэхүүн	Хүнсний ногоо жимс жимсгэнэ
1	Үдийн цай хөтөлбөр	Гэгээн их ХХК	Софтвишн ХХК	Софтвишн ХХК	Софтвишн ХХК
2	Дотуур байрны хүүхдийн хоол	Цагаан дэнжийн хишиг ХХК	Софтвишн ХХК	Софтвишн ХХК	Софтвишн ХХК

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардалд БШУСайдын 2023.05.19-ны өдрийн А/230 тушаалаар 128,956.4 мянган төгрөг батлагдсанаас цахим анги байгуулахтай холбоотой 90 ширхэг 75,681.0 мянган төгрөгийн бага болон дунд оврын Chromebook-4, 23,789.2 мянган төгрөгийн ширээ сандал, 19,965.0 мянган төгрөг 2 ширхэг 86 инчийн ухаалаг дэлгэц, 2,090.0 мянган төгрөгийн 1-р хоолны цахилгаан тогоо, 1,298.0 мянган төгрөгийн 1 ширхэг хурдны скайнер /Epson-DS530/ , 760.0 мянган төгрөгийн таблет цэнэглэгч хайрцаг, 1369.0 мянган төгрөгийн принтер 2 ширхэг, 4,000.0 мянган төгрөгийн Фүлт /Yamaha MG16/ тус тус худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай сургуулийн сургууль Номгон аудит ХХК-д 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэхээр санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2024.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн нийт зардлаар 4,484,944.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 44,336.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 33,252.6 мянган төгрөгөөр тогтоосон.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно. Тайлант онд цалин, шимтгэлийн зардлыг

146,962.4 мянган, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 40,164.3 мянган, үдийн цайны зардлыг 53,230.3 мянган төгрөгөөр хэмнэж, оны эцэст 275,252.5 мянган төгрөг зарцуулаагүй үлдэгдэл харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ нь тайлант оны эцэст дээд газраас нэмэлт санхүүжилт олгосон мөн 2023.09.01-нээс дотуур байрны үйл ажиллагааг зогсоосон, сургалтын үйл ажиллагаа цахимд шилжсэнтэй холбоотой хэмнэлт үүссэн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 996,445.9 мянган төгрөгийн 60 гүйлгээ, зарлагын 6,362,822.6 мянган төгрөгийн 59 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 159,486.3 мянган төгрөгийн 21 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор гүйцэтгэж, менежментийн захидлаар зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,003.4	3	1,003.4	100
Албан шаардлага	1	78051.2	1	78051.2	100
Зөвлөмж	2	330.0	2	330.0	100
Нийт дүн	4	79,100.4	6	79,100.4	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын Номундалай сургуулийн 2023.06.08-ны өдрийн 1/277 тоот албан бичиг



Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.06.08-ны өдөр 1/277 дүгээр албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гаргаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

---oOo---